



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 301

Улаанбаатар хот

Г Албан журмын даатгагчдын холбооны Ү
удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12¹.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Даатгалын тухай хуулийн 12¹ дугаар зүйлд заасан Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг дараах байдлаар баталсугай:

Дарга:

Г.Хэрлэн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн;

Гишүүд:

Ц.Баярхүү Сангийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын даатгалын бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн;

С.Мандахбат Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын орлогч дарга;

С.Энхтуул Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын орлогч дарга;

П.Ганзориг Монголын даатгагчдын холбооны ерөнхийлөгч;

Ш.Батчимэг Даатгалын зуучлагч “Ачит ундарга” ХХК-ийн захирал;

Д.Цэвээнжав Даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах “ДЭХ” нийгэмлэг /ТББ/-ийн удирдах зөвлөлийн дарга.

2. Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН